

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН
2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Аудитын код: САГ-2018/11/СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 260512 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Жавхлан
Аудитор Ж.Болормаа

Утас: 261628 Цахим хаяг: javkhlан@audit.gov.mn
bolormaaj@audit.gov.mn

Улаанбаатар хот



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил	1
2.2	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	2
2.5	Дотоод хяналт	3
2.6	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	3
2.7	Шилэн дансны мэдээлэл.....	4
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	4
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.9.1	Санхүүгийн тайлангийн нэгтгэлийн талаар.....	4
2.9.2	Авлагын талаар.....	4
2.9.3	Гэрээт ажлын санхүүжилтийн бүртгэлийн талаар.....	4
2.9.4	Гэрээт ажлын гүйцэтгэлийн талаар	5
2.9.5	Төслийн сонгон шалгаруулалтын талаар	5
2.9.6	Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн алдаа, зөрчлийн талаар.....	5
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	5
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	6
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	6
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	6
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	6
3	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ	8
3.1	ӨР ТӨЛБӨРИЙН БҮРТГЭЛИЙН ТАЛААР	9
3.2	АВЛАГЫН ТАЛААР	9
3.3	САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТИЙН ТАЛААР	10
3.4	ГЭРЭЭТ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААР	10
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	11
4.1	Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2	Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3	Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
4.4	Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
Б.НЯМДАВАА ТАНАА

2018.03.23 № 06/8/7
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



071447

Аудитын гол асуудал

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшингээс давсан нь "Хязгаарлалттай" санал дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд,

- Зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу хийгдэхгүй байгаагаас авлага үүссэн,
- Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн сонгон шалгаруулалтад шалгарсан зарим төслүүд нь шалгуур үзүүлэлт хангаагүй зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Б.Нямдаваа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд Сангийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.


Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 03 дугаар сарын 05-наас 03 дугаар сарын 25-ны хооронд хийж, аудитын тайланг Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Жавхлан, аудитор Ж.Болормаа нар гүйцэтгэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/221 дугаартай албан ёсоор Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.



2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа буюу хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг санхүүжүүлдэг сан юм.

Дээрх зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно” гэж заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга нь Сангийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны төсвийг Сангийн яамны Төрийн сангаас олгож, хяналт тавьж ажилласан байна.

Тус газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан болно

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. Тухайлбал,

- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажилах хүч, мэргэжилтэн авах тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолууд
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох заавар, журмууд байна.

2.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.


Аудитаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 4 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 22 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим, сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд Нийгмийн халамж үйлчилгээний байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг ашигладаг боловч шинэчлэл хийгдээгүй байна.



Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах, тайлан гаргах ажиллагааг санхүүгийн “Axploger” програмаар, нэгтгэлийг “Талст 1.03” програмаар гүйцэтгэсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Хяналт мониторингийн газар 2017 онд 21 аймаг, 9 дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт мониторинг хийхээр төлөвлөсөн боловч хийгдээгүй байна.

Дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон боловч дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөгүй” байна.

2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар


Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын зүйл ангиар хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дугаар тогтоолоор хөдөлмөр эрхлэлтийн 2 нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 6 төсөл, хөтөлбөрийг тайлант онд хэрэгжүүлэхээр баталсны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын мөн өдрийн А/17 дугаар тушаалаар 83,281.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 61,498.0 сая төгрөгийг зарцуулахаар төсөв баталсан байна. Үүнээс, 40,881.6 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөж тайлант оны эцэст дансны үлдэгдэл 39,244.0 сая төгрөгийг Төрийн санд төвлөрүүлж авлагаар бүртгэсэн байна.

Дээрх баталсан төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсөвтэй харьцуулан хүснэгтээр харуулбал:
/сая төгрөг/

Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
Урсгал зардал	61,498.0	53,246.9	(8,251.1)
Бараа, ажил үйлчилгээний зардал	198.0	157.2	(40.8)
Урсгал шилжүүлэг	41,300.0	33,089.7	(8,210.3)
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	20,000.0	20,000.0	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	83,281.6	92,491.0	9,209.4
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	42,000.0	50,583.1	8,583.1
Туслах үйл ажиллагааны орлогоос	400.0	1,024.3	624.3
Өмнөх оны үлдэгдлээс санхүүжих	40,881.6	40,883.6	2.0

Дээрх хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд 49168 ажлын байр шинээр бий болж, 79898 хүн хамрагдаж, 35,378.0 сая төгрөг зарцуулсан байна.



2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 5,6,7 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn веб сайтад 3 төрлийн мэдээллийг оруулсан байна.

Цахим хуудсанд төсөв/гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт, бусад гэсэн мэдээллийн ангиллаар төрийн сан дахь харилцах дансны гүйлгээ, байгууллагын даргын тушаал шийдвэр, гэрээ зэрэг холбогдох мэдээллийг байршуулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 30 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 22 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Санхүүгийн тайлангийн нэгтгэлийн талаар

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн татаас санхүүжилтийн авлагыг 2.3 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

2.9.2 Авлагын талаар

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сангийн авлага 94,288.1 сая төгрөг тайлагнаснаас тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй эргэн төлөгдөх найдваргүй 847.5 сая төгрөг нь татан буугдсан Анод банк болон Дэлгэр экспресс ББСБ-аас авах авлага байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өгөх

2.9.3 Гэрээт ажлын санхүүжилтийн бүртгэлийн талаар

Жоб матчинг системийг нэвтрүүлэх 352.8 сая төгрөгийн өртөг бүхий зөвлөх үйлчилгээний тендерт 2016 онд шалгарсан Онлайн пи ар эженси ТББ-д олгох гэрээт ажлын үлдэгдэл төлбөр 70.5 сая төгрөгийг өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөрөөр бүртгээгүй боловч тайлант онд төлбөрийг барагдуулж өмнөх үеийн үр дүнд хаасан байна.

ХХҮЕГ-ын даргын 2017 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/314 дүгээр тушаалаар хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг дэмжих хүрээнд төрийн болон төрийн бус 10 байгууллагаар сургалт, судалгаа, үнэлгээ хийлгэх нийт 459.5 сая төгрөгийн санхүүжилт баталсны 70 хувь буюу 321.6 сая төгрөгийг олгож зардалд бүртгэсэн зарын нийтлэг бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

2.9.4 Гэрээт ажлын гүйцэтгэлийн талаар

Тайлант онд програм хангамжийн чиглэлээр нийт 231.8 сая төгрөгийн 11 ажил хийгдсэнээс Монголиан эгзекьютерс ХХК-ийн 18.9 сая төгрөгийн өртөгтэй “Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгааллын веб-д суурилсан зураглал програм боловсруулах” гэрээт ажлын гүйцэтгэлийн тайлан хангалтгүй, ажлын даалгавар тодорхойгүй, гэрээт ажлын гүйцэтгэлийг актаар хүлээн аваагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өгөх

2.9.5 Төслийн сонгон шалгаруулалтын талаар

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 03 дугаар тогтоолоор Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл хэрэгжүүлэх чиглэл, тавигдах ерөнхий шаардлага, шалгуур үзүүлэлтийг баталсан байна.

Төслийн сонгон шалгаруулалтаар нийт 3,986.0 сая төгрөгийн 29 төсөл шалгарсан боловч зарим төсөл нь хөтөлбөр, төслийн тэргүүлэх чиглэлд хамааралгүй, ерөнхий шаардлагад нийцэхгүй, шалгуур үзүүлэлт хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2.9.6 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн алдаа, зөрчлийн талаар

Санхүүгийн нэгтгэсэн тайланд 33 тайлан нэгтгэгдсэнээс Төв сангийн тайлан түүвэрт хамрагдаж, 1 сангийн тайланд итгэл үзүүлж, 21 сангийн тайлан Зөрчилгүй, 10 сангийн тайлан Хязгаарлалттай санал дүгнэлт авсан байна.

Орон нутаг, Нийслэлийн харьяа дэд сангуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,457.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 116.7 сая төгрөгийн 4 акт, 773.4 сая төгрөгийн 8 албан шаардлага, 567.7 сая төгрөгийн 41 зөвлөмж өгөгдсөн байна. Үүнд,

- Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Сүхбаатар аймгууд дах Сангуудын олгосон зээлийн хуваарийн дагуу хийгдээгүй эргэн төлөлтийн 116.7 сая төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт,
- Дорнод, Сэлэнгэ, Төв, Ховд аймгууд, Хан-Уул, Баянгол, Сүхбаатар дүүргүүд дэх Сангуудын хугацаа хэтэрсэн зээлийн авлагуудыг барагдуулах 773.4 сая төгрөгийн албан шаардлага өгсөн байна.

Дээрх Хязгаарлалттай дүгнэлт авсан сангуудын нийт төсөв 7,962.6 сая төгрөг нь орон нутаг дах сангуудын нийт төсвийн 29.8 хувийг эзэлж байна.

Нийслэл болон орон нутаг дах Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 11 тайланд Хараат бус аудитын компани, 21 тайланд Аймгууд дах Төрийн аудитын байгууллага аудит хийж дүгнэлт гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өгөх

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Засгийн газрын 2016 оны 201, 2017 оны 99, 145 дугаар тогтоолуудаар нийт 13 аж ахуйн нэгж, байгууллагын 4567 гадаадын иргэнийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлснөөр 7,899.7 сая төгрөгийн, Засгийн газрын 2015 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 41 дугаар тогтоолоор батлагдсан “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-ын 3.1.6-д “боловсролын байгууллага, шинжлэх ухааны салбарт гэрээгээр ажиллаж байгаа гадаадын

зөвлөх мэргэжилтэн, багш, эрдэм шинжилгээний ажилтанг ажлын байрны төлбөрөөс чөлөөлнө” гэж заасны дагуу 1294 гадаадын иргэнийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлж 4,640.3 сая төгрөг нийт 12,540.0 сая төгрөгийн орлого төвлөрөх боломжийг алдсан байна.

Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөгдсөн боловсролын байгууллагуудын жагсаалтыг харахад сургалтын төлбөр харьцангуй өндөр хувийн сургуулиудад ажиллаж байгаа гадаадын иргэд олонхи байна.

Дээрх Засгийн газрын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан журмын холбогдох заалтыг өөрчилснөөр Улсын төсвийн орлого нэмэгдэх боломжтой юм.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан Төслийн гэрээний 3 дугаар зүйлийн 3.4-д заасны дагуу төслийн явцын тайланг авч олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавих шаардлагатай гэж үзлээ.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 1.871.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнээс 323.9 сая төгрөгийн алдааг залруулж, 116.7 сая төгрөгийн 4 акт, 773.4 сая төгрөгийн 9 албан шаардлага, 657.1 сая төгрөгийн 45 зөвлөмж өгөгдсөн байна.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх аудитаар өгсөн 3 албан шаардлага, 6 зөвлөмжийн хэрэгжилтийг хянахад бүтэц орон тооны талаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна. Энэ нь тус сангийн удирдлага шийдвэрлэхэд хүндрэлтэй зөвлөмж байна.

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 1/1047 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн бөгөөд албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 80.6 хувь байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитын төлөвлөх ба гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг АОУС 320-ын дагуу тодорхойлсон болно.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн материаллаг байдлын түвшинг гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцож санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 1 хувь буюу 866.2 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурийг төлөвлөснөөс өөрчлөөгүй боловч тайлант онд орлого, зарлага өмнөх оноос өссөн тул суурийг 1 хувь болгон багасгаж санхүүгийн тайлангуудын орлого зардлын нэгтгэл болон хоорондын гүйлгээний устгах бичилтийг тулган шалгах нэмэлт горим, сорил хэрэгжүүлэв.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.

Аудитын гол асуудал

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшингээс давсан нь “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд,

- Зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу хийгдэхгүй байгаагаас авлага үүссэн,
- Орон нутаг, нийслэлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн сонгон шалгаруулалтад шалгарсан зарим төслүүд нь шалгуур үзүүлэлт хангаагүй зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим чиглэгдсэн.

Энэ нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн албаны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан асуудал цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар нэгтгэн харуулав.

Дараах зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.



3.1 ӨР ТӨЛБӨРИЙН БҮРТГЭЛИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Жоб матчинг системийг нэвтрүүлэх 352.8 сая төгрөгийн өртөг бүхий зөвлөх үйлчилгээний тендерт 2016 онд шалгарсан Онлайн пи ар эженси ТББ-д олгох гэрээт ажлын үлдэгдэл төлбөр 70.5 сая төгрөгийг өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөрөөр бүртгээгүй боловч тайлант онд төлбөрийг барагдуулж өмнөх үеийн үр дүнд хаасан байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан бодитой илэрхийлэгдэхгүй байх, холбогдох хуулийн заалт хэрэгжихгүй байх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлээр танилцуулсан энэхүү алдаа, зөрчлийг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

3.2 АВЛАГЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сангийн авлага 94,288.1 сая төгрөг тайлагнаснаас тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй эргэн төлөгдөх найдваргүй 847.5 сая төгрөг нь татан буугдсан Анод банк болон Дэлгэр экспресс ББСБ-аас авах авлага байна.

ҮАГ-ын зөвлөмж

НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйл и йн 20.2.6-д “ ... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг баримталж ажиллах


Санхүүгийн тайлангийн дуусвар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангах

Эрсдэлүүд

Хуулийн заалт хэрэгжихгүй байх, эзэн холбогдогч тодорхойгүй, найдваргүй авлага нэмэгдэх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлээр танилцуулсан энэхүү алдаа, зөрчлийг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.



3.3 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Санхүүгийн нэгтгэсэн тайланд 33 тайлан нэгтгэгдсэнээс Нийслэл, дүүргийн 10 дэд сангийн санхүүгийн тайланд Хязгаарлалттай дүгнэлт өгсөн байна.

Дээрх Хязгаарлалттай дүгнэлт авсан дэд сангуудын төсөв орон нутгийн сангуудын нийт төсвийн 29.8 хувийг эзэлж байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх” гэсэн зарчмыг хэрэгжүүлж ажиллах

Эрсдэлүүд

Санхүүгийн сахилга хариуцлага алдагдах, төсвийн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт сулрах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлээр танилцуулсан энэхүү алдаа, зөрчлийг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

3.4 ГЭРЭЭТ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Тайлант онд програм хангамжийн чиглэлээр нийт 231.8 сая төгрөгийн 11 ажил хийгдсэнээс Монголиан эгзекьютерс ХХК-ийн 18.9 сая төгрөгийн өртөгтэй “Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгааллын веб-д суурилсан зураглал програм боловсруулах” гэрээт ажлын гүйцэтгэлийн тайлан хангалтгүй, ажлын даалгавар тодорхойгүй, гэрээт ажлын гүйцэтгэлийг актаар хүлээн аваагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж


Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг баримталж ажиллах

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, гэрээт ажлын гүйцэтгэл шаардлага хангахгүй байх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлээр танилцуулсан энэхүү алдаа, зөрчлийг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.



4 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

4.1 Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

Үзүүлэлт	/мянган төгрөг/	
	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	97,179,777.5	112,079,670.9
МӨНГӨН ХӨРӨНГӨ	5.2	-
Кассанд байгаа бэлэн мөнгө	1.1	
Төгрөг	1.1	
Банкинд байгаа бэлэн мөнгө	4.1	-
Төгрөг	4.1	-
Арилжааны банк дахь харилцах – төгрөг	4.1	-
АВЛАГА	97,179,772.3	11,625,640.9
Татаас, санхүүжилтийн авлага	40,883,574.3	39,244,002.9
Зээлийн хүүгийн авлага	631.2	-
Бусад авлага	3,208,118.3	3,981,546.9
Байгууллагаас авах авлага	2,757,182.7	2,841,905.3
Хувь хүмүүсээс авах авлага	450,935.6	1,139,641.6
Зээлийн авлага	53,088,079.7	68,400,091.1
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	53,088,079.7	68,400,091.1
Хувь хүмүүст олгосон зээл	8,335,628.9	20,626,295.0
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	44,752,450.8	47,746,388.1
УРЬДЧИЛГАА	-	454,030.0
Урьдчилж гарсан зардал	-	454,030.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	97,179,777.5	112,079,670.9
НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	2,596,852.2	269,973.4
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,596,852.2	269,973.4
Богино хугацаат зээлийн өглөг	1,170,542.6	33,795.9
Төгрөг	1,170,542.6	33,795.9
Хувь хүмүүст олгосон зээл	1,170,542.6	33,795.9
Өглөг	1,426,309.7	236,177.5
Ажилчидтай холбогдсон өглөг	54,447.9	1,027.9
Зээлийн хүүгийн өглөг	631.2	-
Бусад өглөг	1,371,230.6	235,149.6
Байгууллагад төлөх өглөг	1,002,606.3	230,307.9
Хувь хүмүүст төлөх өглөг	368,624.3	4,841.7
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	94,582,925.2	111,809,697.5
Засгийн газрын хувь оролцоо	94,582,925.2	111,809,697.5
Хуримтлагдсан үр дүн	94,582,925.2	111,809,697.5
Өмнөх үеийн үр дүн	100,259,840.1	93,190,200.3
Тайлант үеийн үр дүн	(5,676,914.9)	18,619,497.2
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	97,179,777.5	112,079,670.9

01


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.2 Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Үзүүлэлт	/мянган төгрөг/	
	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	31,705,082.7	32,401,815.7
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,705,082.7	32,097,815.7
Нийтлэг татварын бус орлого	31,705,082.7	32,097,815.7
Төсөвт байгууллагын өөрийн орлого	31,705,082.7	32,097,815.7
Үндсэн үйл ажиллагааны орлого	31,282,484.7	31,073,507.9
Туслах үйл ажиллагааны орлого	422,598.1	1,024,307.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	26,381,929.2	304,000.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	304,000.0
Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	304,000.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	37,381,997.6	13,782,318.5
УРСГАЛ ЗАРДАЛ	37,381,997.6	13,782,318.5
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	150,269.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	150,269.4
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	150,269.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,381,997.6	13,632,049.1
Бусад урсгал шилжүүлэг	37,381,997.6	13,632,049.1
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	37,381,997.6	13,632,049.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(5,676,914.9)	18,619,497.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(5,676,914.9)	18,619,497.2

4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Засгийн газрын хувь оролцоо	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
Өмнөх оны эхний үлдэгдэл	94,582,925.2	-	94,582,925.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	100,259,840.1	-	100,259,840.1
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
Тайлант үеийн үр дүн	(576,914.9)	-	(576,914.9)
Өмнөх оны эцсийн үлдэгдэл	94,582,925.2	-	94,582,925.2
Тайлант оны эхний үлдэгдэл	94,582,925.2	-	94,582,925.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,392,724.9)	-	(1,392,724.9)




Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Дахин илэрхийлсэн үлдэгдэл	93,190,200.3	-	93,190,200.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
Тайлант үеийн үр дүн	18,619,497.2	-	18,619,497.2
Тайлант оны эцсийн үлдэгдэл	111,809,697.5	-	111,809,697.5

4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	75,800,267.5	93,883,261.7
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	75,800,267.5	93,579,261.7
Нийтлэг татварын бус орлого	75,800,267.5	93,579,261.7
Төсөвт байгууллагын өөрийн орлого	75,800,267.5	93,579,261.7
Үндсэн үйл ажиллагааны орлого	30,471,793.3	51,671,379.6
Туслах үйл ажиллагааны орлого	448,145.3	1,024,307.8
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	44,880,328.9	40,883,574.3
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,858,541.6	304,000.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	304,000.0
Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	304,000.0
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	75,800,262.4	73,883,266.8
УРСГАЛ ЗАРДАЛ	75,800,262.4	73,883,266.8
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	157,232.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	157,232.5
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	157,232.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,800,262.4	73,726,034.4
Бусад урсгал шилжүүлэг	34,916,688.05	34,482,031.4
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	34,916,688.1	34,482,031.4
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	40,883,574.3	39,244,002.9
Төвлөрүүлэх шилжүүлэг	40,883,574.3	39,244,002.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	5.2	19,999,994.8
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)		120,000,000.0
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		20,000,000.0



Эргэж төлөгдөх зээл		20,000,000.0
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)	5.2	(5.2)
Мөнгөн хөрөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		5.2
Мөнгөн хөрөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5.2	-

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Тайлант оны гүйцэтгэл	/төгрөгөөр/
			Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,498,000,000.0	53,246,997,878.2	8,251,002,121.8
УРСГАЛ ЗАРДАЛ	41,498,000,000.0	33,246,997,878.2	8,251,002,121.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	198,000,000.0	157,232,446.0	40,767,554.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	198,000,000.0	157,232,446.0	40,767,554.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	198,000,000.0	157,232,446.0	40,767,554.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,300,000,000.0	33,089,765,432.2	8,210,234,567.8
Бусад урсгал шилжүүлэг	41,300,000,000.0	33,089,765,432.2	8,210,234,567.8
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	41,300,000,000.0	33,089,765,432.2	8,210,234,567.8
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	20,000,000,000.0	20,000,000,000.0	-
Эргэж төлөгдөх зээл	20,000,000,000.0	20,000,000,000.0	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	61,498,000,000.0	51,607,421,344.0	9,890,578,655.9
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжих	61,498,000,000.0	51,607,421,344.0	9,890,578,655.9
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	61,098,000,000.0	50,583,113,573.0	10,514,886,426.9
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	400,000,000.0	1,024,307,771.0	(624,307,771.0)
Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	5,150.0	(5,150.0)
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-		

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ